

“Даалгаврын сангийн автоматжуулалт” төсөл

Төслийн үндэслэл

Дэлхий нийтээр боловсролын үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь байнгын тогтмолжсон тест, сэдэв, даалгаврын програмчилсан сантай байдаг бөгөөд үүндээ тулгуурлан үнэлгээний материалыг бодитой, чанартай, үр өгөөжтэй шалгалт болон судалгаа зохион байгуулаж үнэлгээний үйл ажиллагаагаа явуулдаг байна.

БСШУЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь (цаашид БҮТ гэх) бүх шатны боловсролын үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх үндсэн үүрэгтэй бөгөөд одоогийн байдлаар элсэлтийн ерөнхий шалгалт, бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Үнэлгээ хийх материал болох шалгалт, судалгааны материалыг боловсруулахдаа багш, судлаач, шинжээчээс бүрдсэн олон хүнийг дайчлах замаар боловсролын үнэлгээ, элсэлт шалгалтын дүнг гаргах, олон нийтэд мэдээллийг түгээх ажлуудыг зохион байгуулдаг. Гэвч энэ бүхэн нь цаг хугацаа, хөрөнгө хүч ихээхэн зарцуулсан, нууцлал болон үр дүнд зарим алдаа үүсгэж, эрсдэлийг бас өөртэй агуулж болох талтай учраас бид бүх шатны боловсролын үнэлгээ хийх бүхий л процесст орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан даалгаврын сангийн автоматжуулалтыг бий болгох дотоодын ажлын зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Иймд уг асуудлыг бодиттой шийдвэрлэх зорилгын үүднээс БҮТ-ийн стратеги төлөвлөгөөнд туссан цогц ажлын хүрээнд энэхүү төслийг боловсруулж байна.

Төслийн зорилго

Төслийн зорилго нь БҮТ-ийн үнэлгээ хийх даалгаврын стандартчилагдсан сан, программ хангамжын автоматжуулсан систем бий болгоход оршино. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- I. Стандартчилагдсан даалгаврын нэгдсэн санг үүсгэх
- II. Программ хангамжыг бий болгох
- III. Шалгалт, судалгаа буюу үнэлгээ хийхэд сангийн материалыг ашиглах, турших
- IV. Санг баяжуулах, байнгын үйл ажиллагаатай болгох үндсэн нөхцлийг төлөвшүүлэх

Төслөөс гарах үр дүн

Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнгүүдэд хүрсэн байна.

- БҮТ нь даалгаврын нэгдсэн сангийн программ хангамжтай болно
- 15 чиглэлээр 50 000 гаруй даалгаврын сантай болно
- Даалгавар тус бүр дээр мэдээлэл хадгалагддаг болсон байна
- ЭЕШ болон бүх шатны боловсролын үнэлгээ хийх материалтай болно
- Даалгавар зохиох, анализ хийх, турших, статистик боловсруулах арга зүй, аргачлалтай болно
- Мэргэжлийн чадварлаг багтай болно
- Үйлчилгээ үзүүлэх боломжтой болно
- Үнэлгээний мэргэжилтэн бэлтгэх эх суурьтай болно
- Онлайнаар шалгалт зохион байгуулах боломжтой болно
- Шалгалтын сэдэв зохиохоор олон хүнийг төвлөрүүлэн зохиож олон хүний хүч хөдөлмөр, хөрөнгө зарлагдах нь багасна